



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Г Дотоод хяналт шалгалтыг зохион Г
байгуулах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Газрын дүрмийн 7.1.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын дотоод үйл ажиллагаа “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА


С.ТӨМӨРДУЛАМ

1150500252